

**СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ  
ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 11 дүгээр  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн А.Бакей

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөлд “уран сайхны хөтөлбөрт нэвтрүүлэг”, “үндэсний нэвтрүүлэг”, “үндэсний кино” гэсэн нэр томъёог Соёлын тухай хуульд шинээр нэмж оруулахаар тусгасан бөгөөд Олон нийтийн радио, телевиз болон Монгол улсад бүртгэлтэй бусад телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулах уран сайхны хөтөлбөрт нэвтрүүлэгт үндэсний нэвтрүүлэг, үндэсний киноны эзлэх хувийг тодорхой зааж, хязгаарлалт тогтоохоор тусгасан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар үндэсний уран бүтээлчдийн эрэлт сайжирч, телевиз, радио болон кабелийн сувгаар дамжуулагдаж байгаа уран сайхны кино, теле жүжиг, телевизийн олон ангит кино, хөгжөөнт хөтөлбөр, тоглолт, баримтат болон хүүхэлдэйн кино, газар зүй, түүх, соёл, зан заншил, хэл зохиол, зан үйл, соёлын өвийг таниулсан бүтээлүүдийн агуулгын зохистой харилцааг бий болгож, иргэд үндэсний эрх ашиг, соёл, хэл, зан заншлаа дээдлэх, хүүхдэд зориулсан болон Монгол улсад бүтээсэн бүтээл нэмэгдэх боломж бүрдэнэ гэж төсөл санаачлагч үзжээ.

Тус Байнгын хороогоор хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэ төсөлд тусгагдсан хувь хэмжээг хэрэгжих боломж, нөхцөлтэйгээ уялдуулах, Улсын Их Хурлын гишүүн А.Бакей хуульд нэмэлт оруулсан зохицуулалт нь хэлбэр төдий байна, агуулга талаас нь хандах нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл телевиз, радио, кабелийн сувгуудад төрөөс тодорхой дэмжлэг үзүүлдэг болсны дараа хуульд нэмэлт оруулах асуудлыг ярих нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргасан болно.

Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

**Д.БАТЦОГТ**

